Эс Жи Эм Ди-Аудит ХХК

МОНГОЛЫН НОГООН САНХҮҮГИЙН КОРПОРАЦИ ББСБ

Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн Санхүүгийн Тайлан болон хараат бус аудиторын дүгнэлт

Улаанбаатар хот, 2026 он

“Монголын Ногоон Санхүүгийн Корпораци” ББСБ

Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани

2025 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн

САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Улаанбаатар хот, 2025 он

ГАРЧИГ хуудасны дугаар

Байгууллагын талаарх мэдээлэл 3

Удирдлагын хариуцлагын мэдэгдэл 4

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН 5-6

2025 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
ОРЛОГО ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН 7

2025 оны 12 сарын 31-ний өдрөөрх
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН 8

2025 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН 9

2025 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН 10

2025 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ 11

Тайлагнагч аж ахуйн нэгж 11

1. Тайлан бэлтгэсэн үндэслэл 11
2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудын хураангуй 12-17
3. Хүү, түүнтэй адилтгах орлого 18
4. Үйл ажиллагааны бус орлого 18
5. Боловсон хүчний зардал 18
6. Үйл ажиллагааны бусад зардал 19
7. Үйл ажиллагааны бус бусад орлого 19
8. Орлогын албан татвар 19
9. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө 20
10. Харилцагчдад олгосон зээл (цэвэр) 20
11. Бусад актив –цэвэр 20
12. Өмч, барилга, тоног төхөөрөмж (цэвэр) 21
13. Хувьцаат капитал 21
14. Бусад өглөг 22
15. Өөрийн хөрөнгийн хүрэлцээ 22
16. Эрсдлийн удирдлага 23
17. Зах зээлийн бодит үнийн мэдээлэл 24
18. Харьцуулах үзүүлэлтүүд 24
19. Балансын дараах үйл явц 24

Байгууллагын талаарх мэдээлэл

Үүсгэн байгуулах шийдвэр	"СИ ЖИ ЭФ Финанс ББСБ" ХХК (цаашид "ББСБ" гэх) анх 2014 оны 12 сард банк бус санхүүгийн байгууллагын хэлбэрээр байгуулагдаж, улсын бүртгэлийн гэрчилгээ авсан. 2014 оны 02 сард Зээлийн үйл ажиллагаа эрхлэх чиглэлээр улсын бүртгэл бүртгүүлж, 2014 оны 2 дугаар сарын 28-ны өдөр Улсын Бүртгэлийн 9015005069 тоот гэрчилгээ авсан. (Регистрийн дугаар 5801826). 2020 оны 04 сарын 13-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр Си Жи Эф ХХК-ийн 100 хувийн хөрөнгө оруулалт бүхий компани болж, оноосон нэрийг "Монголын Ногоон Санхүүгийн Корпораци ББСБ" ХХК болгон өөрчилсөн. 2020 оны 07 сарын 07-ны өдрийн ТУЗ-ын 20200707/01 тоот тушаалын дагуу компанийн дүрмийг шинэчлэн баталсан.
Тусгай зөвшөөрөл	2015 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн СЗХ-ны 166 дугаар тогтоолоор ББСБ-ын зээлийн үйл ажиллагаа эрхлэх 1/462 тоот гэрчилгээ авсан.
Гүйцэтгэх Удирдлага	**М. Болдоо** *Гүйцэтгэх Захирал* **Д. Энхтогтох** *Ерөнхий нягтлан бодогч*
Байнгын хаяг	УБ хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Хөдөлмөрийн ордон МБХ-ны байр 6 давхар
Аудитор	"Эс Жи Эм Ди аудит"ХХК Монгол улс, Улаанбаатар хот СБД 8-р хороо, Оюутны гудамж 14/2и байр 9 тоот

2025 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн тайлан бэлтгэх болон батлах талаарх Удирдлагын хариуцлагын мэдэгдэл

Энэхүү тайлангийн 4-5 дахь хуудсанд тусгагдсан хараат бус аудиторын тайланд дурдсан хараат бус аудиторын дүгнэлттэй хамт уншигдах дараах мэдэгдэл нь "Монголын Ногоон Санхүүгийн Корпораци ББСБ" ХХК -ийн ("ББСБ" гэх) 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн тайлантай холбоотой удирдлагын үүрэг хариуцлага болон аудиторын хариуцлагыг тусад нь илэрхийлэх үүднээс хийгдсэн болно.

Удирдлага нь ББСБ-ын санхүүгийн тайлангуудыг СТОУС болон СЗХ-ны заавар журмын дагуу үнэн зав бэлтгэх үүрэгтэй бөгөөд эдгээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 сарын 31-нээрх санхүүгийн байдал, тайлант жилийн санхүүгийн гүйцэтгэл, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийг СТОУС-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Санхүүгийн тайланг бэлтгэхэд удирдлага нь дараах зүйлсэд хариуцлага хүлээдэг. Үүнд:

- Тохиромжтой нягтлан бодох бүртгэлийн бодлого сонгож, тууштай мөрдөх
- Ул үндэстэй, хянамгай шийдэл гаргах болон тооцоолол хийх
- СТОУС-ыг дагаж мөрдсөн эсэхээ дурдаж, хэрэв материаллаг ялгаа буюу өөрчлөлт байгаа бол санхүүгийн тайланд тодруулж, тайлбарлах
- ББСБ-ын ойрын ирээдүйд бизнесээ үргэлжлүүлнэ гэсэн төсөөлөл нь тохиромжгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайланг тасралтгүй үйл ажиллагааны суурийг үндэслэж бэлтгэх;

Удирдлага нь түүнчлэн,

- Дотоод хяналтын үр дүнтэй, тууштай систем боловсруулж, хэрэгжүүлж, ажиллуулах
- ББСБ-ын санхүүгийн байдлыг аливаа хугацаанд үнэн зөвөөр харуулахуйц нягтлан бодох бүртгэл хөтлөх
- ББСБ-ын нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь санхүүгийн тайланг СТОУС-ын дагуу бэлтгэхүйцээр зохион байгуулагдсан байх
- Хөрөнгийн хадгалалт, хамгаалалтыг хангах арга хэмжээ авч хэрэгжүүлэх
- Заль мэхний асуудал, алдаа болон бусад зөрчлийг илрүүлэх, тэдгээрээс урьдчилан сэргийлэх зэрэг үүрэг хүлээдэг.

Бид эдгээр үүрэг хариуцлагаа ухамсарлан, санхүүгийн тайлангаа Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт, Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох заавар журмын дагуу үнэн зөв бэлтгэсэн гэдгээ баталж байна.

"Монголын Ногоон Санхүүгийн Корпораци ББСБ" ХХК-ийн 2025 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн тайланг гаргахыг зөвшөөрч батлав.

М. БОЛДОО
Гүйцэтгэх захирал

МОНГОЛЫН НОГООН САНХҮҮГИЙН КОРПОРАЦИ
Mongolia Green Finance Corporation NBFI LLC
УЛААНБААТАР ХОТ

Д.ЭНХТОГТОХ
Ерөнхий нягтлан бодогч

Огноо: 2026.03.10
Улаанбаатар хот

SGMD АУДИТ

ЭС ЖИ ЭМ ДИ АУДИТ ХХК

БАТАЛГААЖУУЛАЛТ, АУДИТ, НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ

Огноо 2026/03/10 № 1/6 Улаанбаатар хот

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

"Монголын Ногоон Санхүүгийн Корпораци ББСБ"-ийн Хувьцаа Эзэмшигч-д

Аудиторын дүгнэлт

Бид "Монголын Ногоон Санхүүгийн Корпораци ББСБ" ХХК ("ББСБ" гэх)-ийн дараах тайлангуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийлээ:

- 2025 оны 12 сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан:
- Энэ өдрөөр тасалбар болсон жилийн дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлангууд: болон
- Нягтлан бодох бүртгэлийн томоохон бодлогуудын хураангуйг агуулсан санхүүгийн тайлангийн тэмдэглэлүүд.

Бидний дүгнэлтээр хавсаргасан санхүүгийн тайлангууд нь ББСБ-ын 2025 оны 12 сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаараа Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт ("СТОУС")-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт ('АОУС')-ын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандартын дагуу хүлээх үүрэг хариуцлагыг энэ тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага гэсэн хэсэгт харуулсан. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөл ('НБЁЗОУСЗ')-ийн Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Дүрэм болон Монгол улсад мөрдүүлэхээр шаарддаг санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагуудын дагуу ББСБ-аас хараат бус байж, бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний цуглуулсан аудитын нотолгоо нь гаргасан аудиторын дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай бөгөөд зохистой гэж итгэж байна.

Бусад мэдээлэл

Удирдлага нь бусад мэдээлэлд үүрэг хариуцлага хүлээдэг. Бусад мэдээлэл нь жилийн тайланд орсон мэдээллээс бүрддэг боловч түүнд санхүүгийн тайлан болон бидний аудиторын тайлан ордоггүй.

Санхүүгийн тайланд гаргасан бидний дүгнэлт нь бусад мэдээллийг хамардаггүй бөгөөд бид бусад мэдээллийн талаар аливаа баталгаажилтын дүгнэлт гаргахгүй.

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой бидний хүлээх үүрэг хариуцлага бол бусад мэдээллийг уншиж, бусад мэдээлэл нь санхүүгийн тайлантай эсвэл бидний аудитын явцад олж мэдсэн ойлголттой материаллагаар үл нийцэж байгаа эсэх эсвэл өөр хэлбэрээр материаллагаар буруу илэрхийлэгдсэн байж болзошгүй эсэхийг тодорхойлох явдал юм.

Бид гүйцэтгэсэн ажилдаа үндэслэн бусад мэдээллийг материаллагаар буруу илэрхийлэгдсэн байна гэж дүгнэсэн тохиолдолд энэ талаар тайлагнах шаардлагатай байдаг. Бидэнд үүнтэй холбоотой тайлагнах зүйлс байхгүй болно.

Санхүүгийн Тайланд Удирдлага ба Засаглах Удирдлагын Хүлээх Үүрэг Хариуцлага

ББСБ-ын удирдлага нь санхүүгийн тайлангуудыг СТОУС-ын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулахаас гадна алдаа эсвэл заль мэхнээс үүдэлтэй материаллаг буруу илэрхийллээс ангид санхүүгийн тайлан бэлтгэх боломж бүрдүүлэхэд зайлшгүй шаардлагатай дотоод хяналтыг тодорхойлох үүрэгтэй байдаг.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ ББСБ-ыг татан буулгах юм уу үйл ажиллагааг нь зогсоох эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд удирдлага өөдрөг төсөөллөөр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх ББСБ-ын чадамжийг үнэлж, шаардлагатай бол өөдрөг төсөөлөлтэй холбоотой асуудлуудын талаар тодруулга хийх, нягтлан бодох бүртгэлийн өөдрөг төсөөллийн суурийг ашиглах үүрэг хариуцлага хүлээнэ.

Засаглах удирдлага нь ББСБ-ын санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

Монгол Улс, Улаанбаатар хот
СБД, 8-р хороо, Оюутны гудамж-44
14/2и байр 9 тоот

Утас: 976 (11) 7000 6948
9911 6948
Факс: 976 (11) 7000 6948
И-мэйл: ekhbayar@sgmd-audit.mn
info@sgmd-audit.mn

Санхүүгийн Тайлангийн Аудитад Аудиторын Хүлээх Үүрэг Хариуцлага

Бидний зорилго бол санхүүгийн тайлангууд нь заль мэх эсвэл алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллээс бүхэлдээ ангид эсэх тухай ул үндэслэлтэй баталгаажилт цуглуулж, өөрийн дүгнэлтийг багтаасан аудиторын тайлан гаргах явдал юм. Ул үндэслэлтэй баталгаажилт нь баталгаажилтын өндөр түвшин боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудит нь оршин буй бүх материаллаг буруу илэрхийллийг илрүүлнэ гэсэн баталгаагаар хангахгүй.
Буруу илэрхийлэл заль мэхнээс эсвэл алдаанаас үүсч болох ба энэ нь дангаараа эсвэл бусад буруу илэрхийллүүдийн хамтаар санхүүгийн тайланд үндэслэн түүнийг хэрэглэгчдийн гаргах эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллаг гэж үздэг. АОУС-ын дагуу аудитын ажил гүйцэтгэхдээ бид мэргэжлийн шийдэл гаргаж, мэргэжлийн үл итгэх үзлийг баримтлан ажилладаг. Бид мөн:

- Заль мэх эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллагаар буруу илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирох аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж, өөрсдийн санал дүгнэлтийн үндэслэл болохуйц хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоог олж авдаг. Заль мэх нь хуйвалдаан, баримт бичгийг хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу тайлагнах, дотоод хяналтыг үл ойшоох зэргийг багтаадаг бөгөөд эдгээрээс үүссэн материаллаг алдааг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн материаллаг алдааг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй өндөр байдаг.
- ББСБ-н дотоод хяналтын үр ашигт байдлын талаар санал дүгнэлт гаргах зорилгоор биш харин тухайн нөхцөл байдалд тохирох аудитын горимыг боловсруулах зорилгоор аудитад хамаарах дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогын тохиромжтой байдал, хийсэн нягтлан бодох бүртгэлийн тооцоолол болон холбогдох тодруулгын үл үндэслэлтэй байдлыг үнэлдэг.
- Цуглуулсан аудитын нотолгоонд үндэслэн ББСБ-н тасралтгүйгээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх чадварт томоохон эргэлзээ төрүүлэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг тодорхойлж, нягтлан бодох бүртгэлийн өөдрөг төсөөллийн суурийг удирдлага зохистойгоор хэрэглэсэн эсэхийг дүгнэдэг. Хэрэв бид материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа түүнтэй холбоотой санхүүгийн тайлангийн тодруулгад анхаарал хандуулах эсвэл хийсэн тодруулга нь хангалтгүй байна гэж үзвэл аудитын санал дүгнэлтээ өөрчилдөг. Бидний дүгнэлт нь аудиторын тайлан гаргах өдөр хүртэлх олж авсан аудитын нотолгоонд суурилдаг. Гэвч ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөл байдал нь ББСБ-г өөдрөг төсөөллөө үргэлжлүүлэхээ зогсооход хүргэх нөлөө үзүүлж болно.
- Санхүүгийн тайлан ба түүний тодруулгын ерөнхий толилуулга, бүтэц, агуулгаас гадна санхүүгийн тайлангууд нь үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц хэмжээнд гол ажил гүйлгээ ба үйл явдлыг илэрхийлсэн эсэхийг үнэлдэг.

Бид аудитын төлөвлөсөн цар хүрээ ба хугацаа, аудитын ажлын явцад илрүүлсэн дотоод хяналт дахь томоохон зөрчил дутагдал, аудитын томоохон илрүүлэлтүүд болон бусад асуудлуудаар засаглах эрх бүхий удирдлагатай харилцдаг.

Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 94-р зүйлд заасан хуулийн этгээд болох "Монголын Ногоон Санхүүгийн Корпораци ББСБ" ХХК-ийн хувьцаа эзэмшигчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй.

Огноо: 2026.03.10

Эс Жи Эм Ди Аудит ХХК-ийн захирал Д.Насанжаргал
Монгол улс, Улаанбаатар хот
СБД 8-р хороо, Оюутны гудамж 14/2и байр 9 тоот

“Монголын Ногоон Санхүүгийн Корпораци ББСБ”
Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани

2025 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн ОРЛОГО ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

	ТЭМ	2025 он мян.төг	2024 он мян.төг
Хүү болон түүнтэй адилтгах орлого	4	92,571	113,309
Хүү болон түүнтэй адилтгах зардал		-	-
Зээлийн үнэ цэнийн бууралт		-	-
Хүүгийн цэвэр орлого		**92,571**	**113,309**
Үйл ажиллагааны бусад орлого	5	9,018	25,215
Хүүгийн бус цэвэр орлого		**9,018**	**25,215**
Үйл ажиллагааны нийт орлого		**101,589**	**138,524**
Боловсон хүчний холбогдолтой зардал	6	(31,309)	(33,780)
Арилжааны болон ханшийн тэгшитгэлийн зардал	7	(6,343)	-
Үйл ажиллагааны бусад зардал	8	(21,772)	(9,444)
Үйл ажиллагааны бус бусад орлого(зардал)	9	(3,022)	(2,597)
Татварын өмнөх ашиг /(алдагдал)		**39,143**	**92,703**
Орлогын албан татвар	10	(154)	(720)
Татварын дараах цэвэр ашиг/(алдагдал)		**38,989**	**91,983**

Хавсаргасан тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.

"Монголын Ногоон Санхүүгийн Корпораци ББСБ"
Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани

2025 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

	Тэм	2025 оны 12 сарын 31 мян.төг	2024 оны 12 сарын 31 мян.төг
ХӨРӨНГӨ			
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	11	1,308,516	1,306,130
Зээл /Цэвэр/		-	-
Бусад актив	12	97,499	2,536
ӨБТТ-цэвэр	13	78	162
НИЙТ ХӨРӨНГӨ		**1,406,093**	**1,308,828**
ӨМЧ БА ӨР ТӨЛБӨР			
Өмч			
Хувьцаат капитал	14	1,041,500	1,041,500
Хуримтлагдсан ашиг (алдагдал)		170,515	131,527
Нийт өмч		**1,212,015**	**1,173,027**
Эргэлтийн өр төлбөр			
Бусад өглөг	15	194,078	135,802
Нийт эргэлтийн өр төлбөр		**194,078**	**135,802**
Нийт өр төлбөр		**194,078**	**135,802**
НИЙТ ӨМЧ БА ӨР ТӨЛБӨР		**1,406,093**	**1,308,828**

Хавсаргасан тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.

“Монголын Ногоон Санхүүгийн Корпораци ББСБ”
Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани

2025 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

	Энгийн хувьцаа мян.төг	Хуримтлагдсан ашиг/(алдагдал) мян.төг	Нийт мян.төг
2023 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	**1,041,500**	**39,544**	**1,081,044**
Тайлант жилийн цэвэр ашиг	-	91,983	91,983
2024 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	**1,041,500**	**131,527**	**1,173,027**
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-
Залруулсан үлдэгдэл	**1,041,500**	**131,527**	**1,173,027**
Тайлант жилийн цэвэр ашиг	-	38,989	38,989
2025 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	**1,041,500**	**170,515**	**1,212,015**

Хавсаргасан тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно

“Монголын Ногоон Санхүүгийн Корпораци ББСБ”
Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани

2025 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

	2025 он мян.төг	2024 он мян.төг
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ДҮН	**(291,380)**	**426,956**
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого	**563,522**	**563,522**
Зээлийн хүүгийн орлого		
Харилцах дансны хүүгийн орлого	92,570	113,309
Санхүүжилтийн орлого	-	450,213
Гадаад валютын арилжааны орлого	10	450,213
Гадаад валютын ханшийн зөрүү	(4,584)	450,213
Бусад үйлчилгээний орлого	1,037	-
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага	**(380,413)**	**(136,566)**
Үндсэн ба нэмэгдэл цалин	(103,675)	(104,982)
Нийгмийн даатгал, ЭМД-ийн зардал	(13,063)	(14,379)
Албан томилолт, сургалтын зардал	-	(17)
Шатахуун, холбоо, интернет, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө	(106)	(411)
Бичиг хэрэг, ариун цэврийн зардал	(114)	-
Татвар, даатгалын төлсөн мөнгө	(7,318)	(8,485)
Зар сурталчилгаанд төлсөн мөнгө	(100)	-
Зээл болон түүнтэй холбоотой авлагыг барагдуулахтай холбогдон гарсан мөнгө	(815)	(2,487)
Аудитын төлбөр,мэргэжлийн зөвөлгөө үйлчилгээний мөнгө	(9,900)	(4,880)
Зохицуулалтын үйлчилгээний хураамжид төлсөн мөнгө	(3,280)	-
Бэлтгэн нийлүүлэгчид төлсөн бусад мөнгө	-	-
Бусад үйлчилгээнд төлсөн мөнгө	(242,040)	(100)
ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	**4,228**	**(214,121)**
Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн орлого	**-**	**-**
Үндсэн ба хөрөнгө борлуулсны орлого	-	-
Бусад	7,249	-
Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн зарлага	**(30,21)**	**(214,121)**
Баяр ёслол, зочин төлөөлөгчийн зардал	(3,021)	(2,398)
Бусад	(669)	(211,723)
БҮХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	**(287,151)**	**212,835**
МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	**1,306,130**	**1,093,295**
МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	**1,308,516**	**1,306,130**

Хавсаргасан тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно. Эдгээр тэмдэглэлүүд нь хавсаргасан санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг бөгөөд тэдгээр тайлантай хамт уншигдана.

2025 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ (үргэлжлэл)

1. Тайлагнагч аж ахуйн нэгж

СИ ЖИ ЭФ Финанс ББСБ” ХХК (цаашид “ББСБ” гэх) анх 2014 оны 12 сард банк бус санхүүгийн байгууллагын хэлбэрээр байгуулагдаж, улсын бүртгэлийн гэрчилгээ авсан.

2014 оны 02 сард Зээлийн үйл ажиллагаа эрхлэх чиглэлээр улсын бүртгэл бүртгүүлж, 2014 оны 2 дугаар сарын 28-ны өдөр Улсын Бүртгэлийн 9015005069 тоот гэрчилгээ авсан. (Регистрийн дугаар 5801826).

2020 оны 04 сарын 13-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр Си Жи Эф ХХК-ийн 100 хувийн хөрөнгө оруулалт бүхий компани болж, оноосон нэрийг “Монголын Ногоон Санхүүгийн Корпораци ББСБ” ХХК болгон өөрчилсөн.

2020 оны 07 сарын 07-ны өдрийн ТУЗ-ын 20200707/01 тоот тушаалын дагуу компанийн дүрмийг шинэчлэн баталсан.

2025 оны 12 сарын 31-ний байдлаар хүчин төгөлдөр компанийн дүрмийн дагуу компанийн хувьцаат капитал 1,041,500 мянган төгрөг бөгөөд Монгол улсын аж ахуйн нэгж болох СИ ЖИ ЭФ ХХК нь 100 хувь эзэмшдэг.

2. Тайлан бэлтгэсэн үндэслэл

(a) Даган мөрдөлтийн мэдэгдэл

Эдгээр санхүүгийн тайлангууд нь Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Хороо (“НББОУСХ”)-ноос гаргаж, мөрдүүлсэн Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (“СТОУС”) болон НББОУСХ-ны Тайлбарын Байгын Хорооноос гаргасан тайлбарын дагуу бэлтгэгдсэн байна.

Түүнчлэн, ББСБ нь нягтлан бодох бүртгэлээ Санхүүгийн Зохицуулах Хорооноос баталсан Банк бус санхүүгийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн зааврын дагуу зохион байгуулсан бөгөөд энэхүү зааврыг Санхүүгийн Зохицуулах Хороо нь СТОУС-тай нийцүүлэн гаргасан байна.

(b) Хэмжилтийн үндэслэл

Зах зээлийн бодит үнээрээ бүртгэгдсэн санхүүгийн хөрөнгө, өр төлбөрөөс бусад зүйлсийн хувьд эдгээр санхүүгийн тайлангууд нь түүхэн өртөгт суурилан бэлтгэгддэг.

Тус ББСБ нь нягтлан бодох бүртгэлийн бодлогоо тууштай мөрдсөн бөгөөд энэ нь өмнөх жилд ашигласан бүртгэлийн бодлоготой нийцэж байна.

(c) Үндсэн ба тайлагнагч валют

Эдгээр санхүүгийн тайлангууд нь Монгол улсын төлбөр тооцооны нэгж, ББСБ-ын тайлагнагч валют болох төгрөгөөр илэрхийлэгдэн, мянган төгрөгөөр нарийвчлан харуулж тайлагнагдсан.

(d) Тооцоолол ба үнэлгээний хэрэглээ

Санхүүгийн тайланг СТОУС-ын дагуу бэлтгэх нь удирдлагаас нягтлан бодох бүртгэлийн бодлогын хэрэглээ болон хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тайлагнасан дүн зэрэгт нөлөөлөх үнэлгээ, таамаглал ба тооцоолол хийхийг шаарддаг. Бодит үр дүн нь эдгээр тооцооллоос ялгаатай байж болно.
Үнэлгээ тооцоолол болон гол чухал таамаглалууд нь байнга шалгагдаж байдаг. Нягтлан бодох бүртгэлийн тооцоололд хийсэн өөрчлөлтийг тухайн өөрчлөлт хийгдсэн болон ирээдүйд нөлөөлөх тайлант үеүдэд нь хүлээн зөвшөөрдөг.

Санхүүгийн тайланд тусгагдсан тоон үзүүлэлтүүдэд материаллаг нөлөө үзүүлэхээр нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын хэрэглээ, тооцооллын эргэлзээтэй асуудал байхгүй болно.

(e) Тасралтгүй үйл ажиллагааны зарчим

Санхүүгийн тайлангууд нь тасралтгүй үйл ажиллагааны зарчимд суурилан бэлтгэгдсэн.

Тасралтгүй үйл ажиллагааны зарчмын төсөөлөл хүчинтэй байх эсэх нь компани ирээдүйд тасралтгүй үйл ажиллагаагаа хадгалж чадах эсэхээс хамаарна.

3. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудын хураангуй

(f) Гадаад валютаарх ажил гүйлгээ

Гадаад валютаар хийгдсэн ажил гүйлгээнүүдийг гүйлгээ хийгдсэн өдрийн албан ханшаар хөрвүүлдэг.
Түүхэн өртгөөрөө тусгагдсан гадаад валютаарх мөнгөн хөрөнгө, өр төлбөрийг балансын өдрийн албан ханшаар төгрөгт хөрвүүлдэг. Хөрвүүлэлтээс үүдсэн гадаад валютын ханшийн зөрүүг орлогын тайланд хүлээн зөвшөөрдөг.

(g) Хүү болон түүнтэй адилтгах орлого ба зардал

Хүү бүхий санхүүгийн хэрэглүүрүүдийн хүүгийн орлого, зардлыг холбогдох санхүүгийн хөрөнгө эсвэл өр төлбөрийн үр ашигт хүүгийн хувийг хэрэглэн орлогын тайланд “Хүү болон түүнтэй адилтгах орлого” ба “Хүү болон түүнтэй адилтгах зардал” гэж хүлээн зөвшөөрнө. Үнэ цэнийн бууралтад орсон зээл, урьдчилгааны хүүгийн орлогоос бусад хүүгийн орлогыг аккруэл сууриар дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрнө. Үнэ цэнийн бууралтад орсон санхүүгийн хөрөнгийн хүүгийн орлогыг анхны үр ашигт хүүгийн хувь хэмжээгээр тооцож хүлээн зөвшөөрнө.

(h) Хураамж ба шимтгэлийн орлого

ББСБ-ын хураамж, шимтгэлийн орлого нь ихэвчлэн зээлийн өргөдөл, гүйлгээний болон бусад төрлийн хураамж, гэрээний бүтцэд өөрчлөлт оруулсны шимтгэл, урьдчилсан төлөлтийн

шимтгэл зэргээс бүрддэг. Хураамж, шимтгэлийн орлогыг үйлчилгээ үзүүлсэн хугацаанд нь мөнгөн сууриар хүлээн зөвшөөрдөг.

(i) Татварын зардал

Татварын зардал нь тайлант жилийн болон хойшлуулсан татварын зардлын нийлбэрээс бүрдэх бөгөөд орлогын тайланд тусгагддаг. ББСБ-ын татвар нь тайлант жилийн татвар ногдуулах орлогод ногдох балансын өдрөөр хүчинтэй байгаа татварын хувь хэмжээгээр тооцсон бөгөөд өмнөх үеийн татварын өглөг, хойшлуулсан татвар хөрөнгө ба өр төлбөрийг тохируулсан хүлээгдэж буй татварын хөрөнгө эсвэл өглөг юм.
Хойшлогдсон татвар нь санхүүгийн тайлагналын зорилгоор бүртгэсэн хөрөнгө болон өр төлбөрийн дансны үнэ ба татварын тайлагналын зорилгоор бүртгэсэн үнийн зөрүүнээс үүссэн түр зөрүү юм. Хойшлогдсон татварыг тайлагнах өдрөөрх болон цаашид хэрэгжих хуульд үндэслэн буцаалт хийгдэх түр зөрүүнд хэрэгжихээр хүлээгдэж байгаа татварын хувиар тооцдог. Хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийг татвар ногдуулах нэг аж ахуйн нэгжид хамаарах татварын байгууллагаас тогтоосон тайлант үеийн татвар ногдуулах хөрөнгө, өр төлбөрийн эсрэг хуулийн эрх үүргийн дагуу хооронд нь хааж болох бөгөөд гэхдээ эдгээр татвар ногдуулах хөрөнгө, өр төлбөр нь цэвэр дүнд суурилсан байх хэрэгтэй.

Ирээдүйн татвар ногдуулах ашиг нь татварын түр зөрүүг нөхөхүйц байх тохиолдолд хойшлогдсон татварын хөрөнгийг хүлээн зөвшөөрнө. Хойшлогдсон татварын хөрөнгийг тайлант үе бүрт хянаж холбогдох татварын өгөөжийг хэрэгжүүлэх буюу бууруулдаг.

3. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудын хураангуй (үргэлжлэл)

(j) Үйл ажиллагааны түрээсийн төлбөр

Түрээсийн зардлыг түрээсийн хугацааны турш шулуун шугамын аргаар орлогын тайланд хүлээн зөвшөөрдөг. Түрээсийн урамшууллыг нийт түрээсийн зардлын салшгүй хэсэг болгон орлогын тайланд хүлээн зөвшөөрдөг.

(k) Ажиллагсдын тэтгэвэр, тэтгэмжийн төлөвлөгөө

Ажиллагсдын тэтгэвэр, тэтгэмж нь Монгол Улсын Нийгмийн даатгалын байгууллагад төлж буй нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн төлбөрийг агуулдаг. Энэхүү тодорхойлсон тэтгэмжийн ажил олгогчийн ажилтныхаа өмнөөс төлөх дүнг гарсан үед нь орлогын тайланд зардлаар хүлээн зөвшөөрдөг.

(l) Нэгж хувьцаанд ногдох ашиг

Компани хувьцааны жигнэсэн дундаж тоонд суурилан нэгж хувьцаанд ногдох ашгийг тооцоолсон.

(т) Санхүүгийн хэрэгсэл

i) Санхүүгийн хэрэгслийн анхны хүлээн зөвшөөрөлт

Анх хүлээн зөвшөөрч буй санхүүгийн хэрэгслийн ангилал нь тэдгээрийн зориулалт, шинж чанараас шалтгаална. Санхүүгийн хэрэгслүүдийг анхлан бодит үнээр нь хэмжих ба харин бодит үнийн өөрчлөлт нь ашиг алдагдлаар тайлагнагдахгүй санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн хувьд бодит үнэ дээр тэдгээртэй шууд холбоотой худалдан авалтын эсвэл гаргалтын ахиуц зардлуудыг нэмсэн дүнгээр бүртгэнэ.

ii) Санхүүгийн хэрэгслийн ангилал

Арилжаалах зорилгоор эзэмшиж буй хэрэгслүүд нь ерөнхийдөө ашиг олох зорилгоор богино хугацаанд ББСБ-ын эзэмшиж буй зүйлс юм. Арилжаалах зорилгоор эзэмшиж буй санхүүгийн хөрөнгө эсвэл өр төлбөрүүдийг тайлан тэнцэлд бодит үнээр нь бүртгэнэ. “Арилжааны цэвэр орлого”-д бодит үнийн өөрчлөлтийг тусгана. Хүүгийн орлого эсвэл зардлыг гэрээний нөхцөлийн дагуу эсвэл төлбөрийн эрх үүссэн үед “Цэвэр арилжааны орлого”-д бүртгэнэ. Энэ ангилалд өрийн үнэт цаас, энгийн хувьцаа, ойрын хугацаанд буцаан худалдан авах эсвэл худалдах зорилгоор эзэмшиж байгаа үнэт цааснууд багтана.

3. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудын хураангуй (үргэлжлэл)

(т) Санхүүгийн хэрэгсэл (үргэлжлэл)

Харилцагчдад олгосон зээл нь ББСБ-аас зээлдэгчдэд мөнгө олгох замаар бий болгосон зээл, авлага юм. Энэхүү олгосон зээл ба авлага нь идэвхтэй зах зээл дээр бүртгэлгүй, тогтмол эсвэл тодорхойлох боломжтой төлбөрүүдтэй, тогтсон дуусгавар хугацаатай санхүүгийн хэрэгслүүд юм. Анхны хэмжилтийн дараа харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааг үр ашигт хүүгийн аргыг хэрэглэн хорогдуулсан өртгөөс үнэ цэнэ бууралтын санг хассан дүнгээр бүртгэнэ. Хорогдуулсан өртгийг үр ашигт хүүгийн салшгүй хэсэг болох худалдан авалтын урамшуулал, хөнгөлөлт болон шимтгэлийг оролцуулан тооцно.

Дуусгавар хугацаа хүртэл эзэмших санхүүгийн хэрэгсэл нь ББСБ дуусгавар хугацаа хүртэл нь эзэмших боломжтой, тогтмол буюу тодорхойлогдохуйц төлбөртэй санхүүгийн хөрөнгүүд юм. ББСБ нь дуусгавар хугацаа хүртэл эзэмших хандлага ба чадвартай, тогтмол эсвэл тодорхойлж болохуйц төлбөртэй ба тогтоосон хугацаатай санхүүгийн хэрэглүүрүүдийг дуусгавар хугацаа хүртэл эзэмших санхүүгийн хөрөнгө оруулалт гэнэ. Анхны хэмжилтийн дараа, дуусгавар хугацаа хүртэл эзэмших санхүүгийн хөрөнгө оруулалтыг үр ашигт хүүгийн арга ашиглаж тооцсон хорогдуулсан өртгөөс үнэ цэнийн бууралтыг хассан дүнгээр хэмжинэ. Хорогдуулсан өртгийг үр ашигт хүүгийн салшгүй хэсэг болох худалдан авалтын урамшуулал, хөнгөлөлт болон шимтгэлийг оролцуулан тооцдог. Хорогдуулалт нь ашиг алдагдлын тайлангийн “Хүү болон түүнтэй адилтгах орлого”-д орно. Уг хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралтаас үүссэн алдагдлыг орлого, үр дүнгийн тайлангийн “Санхүүгийн хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралтын алдагдал” хэсэгт хүлээн зөвшөөрнө.

Борлуулах боломжтой санхүүгийн хэрэгсэл гэдэг нь тус ББСБ-аас гаргасан арилжааны зориулалтаар эзэмшээгүй буюу дуусгавар хугацаа хүртэл нь эзэмшихгүй санхүүгийн хөрөнгүүд юм. Эдгээрт өөрийн хөрөнгийн хэрэглүүр, хамтын санд оруулсан хөрөнгө оруулалтууд , мөнгөний зах зээлийн ба бусад өрийн хэрэглүүрүүд багтдаг.

Анх хүлээн зөвшөөрсний дараа борлуулах боломжтой хөрөнгө оруулалтыг бодит үнээр нь хэмждэг. Бодит бус ашиг алдагдлыг өөрийн хөрөнгийн “Борлуулахад бэлэн сан ”-д шууд хүлээн зөвшөөрдөг.
Өрийн бичиг ба зээлээр авсан эх үүсвэр нь тус ББСБ-ын бусад банк, санхүүгийн байгууллагуудаас төвлөрүүлсэн гэрээт эх үүсвэрийг илэрхийлнэ. Өрийн бичиг ба зээлийн эх үүсвэрийг анх өртгөөр хүлээн зөвшөөрнө.
Анх хүлээн зөвшөөрсний дараа, зээлээр авсан санхүүжилт дараагийн тайлант хугацаанд үр ашигт хүүгийн аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр нь хэмжинэ. Хорогдуулсан өртгийг тооцохдоо зээл авах үеийн хөнгөлөлт, урамшуулал ба үр ашигт хүүгийн нэг салшгүй хэсэг болж буй зардлуудыг авч үзнэ.

(n) Арилжааны бус санхүүгийн өр төлбөр

Арилжааны бус санхүүгийн өр төлбөр гэдэгт харилцагчид болон бусад санхүүгийн байгууллагаас авсан хүү бүхий зээллэг болон бусад өглөгүүд орно. Арилжааны бус өр төлбөрийг анх өртгөөр нь тусгадаг. Анхдагч хүлээн зөвшөөрөлтөөс хойш тэдгээр нь хорогдуулсан өртөг буюу өртөг болон үлдэх өртгийн хоорондын зөрүүгийн хамт тусгагдан, үр ашигт хүүгийн аргаар тухайн хэрэгслийн хугацааны турш орлогын тайланд хүлээн зөвшөөрөгддөг.

3. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудын хураангуй (үргэлжлэл)

(o) Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгөн хөрөнгө нь гар дээрх бэлэн мөнгө, арилжааны банкин дахь харилцах данснаас бүрдэж байна.

(p) Зээл ба урьдчилгаа

Тус ББСБ-ын харилцагчдад олгосон зээл нь зээл ба авлагаар ангилагдсан. Эргэн төлөгдөхөөр тооцоолсон дүнг тусгах зорилгоор зээлийн эрсдлийн санг хассан цэвэр дүнгээр тайлагнадаг.

(q) Үнийн бууралт

Үнийн бууралт үүссэн тухай биет нотолгоо байгаа эсэхийг тодорхойлох зорилгоор ББСБ-ын хөрөнгийн дансны үнийг балансын өдөр бүр шалгадаг. Ийм шинж тэмдэг байгаа бол тухайн хөрөнгийн эргэн нөхөгдөх боломжит дүнг тооцдог.

(i) Зээлийн үнийн бууралт

Зээл нь эргэн төлөгдөхөд учирч болзошгүй эрсдэлээс хамгаалах тусгай болон ерөнхий нөөцийг хассан цэвэр дүнгээр илэрхийлэгдсэн. Зээлийн үлдэгдлийг шалгасны үндсэн дээр түүний үнэ нь бодитойгоор буурч байгаа нь тодорхойлогдсон зээлийн дансны үнийг эргэн нөхөгдөх боломжтой дүн хүртэл нь бууруулж, тусгай нөөцийг байгуулдаг. Ижил төрлийн зээлийн багцын дансны үнийг балансын өдрөөрх тооцоолсон эргэн нөхөгдөх боломжтой дүн хүртэл нь бууруулж ерөнхий нөөцийг байгуулдаг. Нөөцийн өсөлтийг орлогын тайланд хүлээн зөвшөөрдөг. Эрсдэлийн нөөцийг байгуулахдаа Монголбанкны ерөнхийлөгч, Сангийн сайдын хамтарсан

тушаалаар баталсан журмыг баримталдаг. Зээл эргэн төлөгдөхгүй нь тодорхой болмогц бүх шаардлагатай эрх зүйн горимуудыг хийж гүйцэтгэсний дараа алдагдлыг тооцож, зээлийг болзошгүй эрсдэлээс хамгаалах сангаас хаадаг. Балансын өдрөөс хойш үнийн бууралтын алдагдлын дүн багасвал, бууруулж бүртгэсний дараа тохиолдсон үйл явдалтай холбогдож бууруулсан бичилт буюу нөөцийг орлогын тайлангаар дамжуулан буцаан бүртгэдэг.

(ii) Бусад хөрөнгийн үнийн бууралт

Мөнгөний орох урсгал бий болгодоггүй хөрөнгүүдийн хувьд эргэн нөхөгдөх дүнг тухайн хөрөнгийн харьяалагдаж буй мөнгө бий болгогч нэгжийнх нь хувьд тодорхойлдог. Хөрөнгийн эсвэл мөнгө бий болгогч нэгжийн дансны үнэ нь эргэн нөхөгдөх үнээсээ давсан үед үнийн бууралтын алдагдлыг орлогын тайланд хүлээн зөвшөөрдөг. Эргэн нөхөгдөх дүнг тодорхойлоход ашигласан тооцоололд өөрчлөлт орсон бол үнийн бууралтын алдагдлыг буцаан бүртгэдэг. Үнийн бууралтын бүх буцаалтыг орлогын тайланд хүлээн зөвшөөрдөг.

3. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудын хураангуй (үргэлжлэл)

(r) Нөөцүүд

ББСБ нь өмнөх үеийн үйл явдлын үр дүнд хууль ёсны хариуцлага хүлээж буй болон эдийн засгийн үр өгөөжийн гарах урсгалд хариуцлагаа биелүүлэх шаардлагатай болсон үед баланст нөөцийг хүлээн зөвшөөрдөг.

- Зээл төлөгдөхөд учирч болзошгүй эрсдэлээс хамгаалах нөөц болон өмчлөх бусад хөрөнгийн борлогдохгүй байх эрсдэлийн түвшин нь он тус бүрийн хувьд дараахь байдалтай байсан:

	2025 он	2024 он
Хэвийн	0%	0%
Анхаарал хандуулах зээл	5%	5%
Хэвийн бус	25%	25%
Эргэлзээтэй	50%	50%
Муу	100%	100%

- Зээл, өмчлөх бусад хөрөнгөөс бусад хөрөнгийн хувьд, түүний эргэн төлөгдөх магадлалын талаарх удирдлагын үнэлгээнд суурилан зөвхөн тусгай нөөцүүдийг байгуулдаг.

4. Хүү, түүнтэй адилтгах орлого

	2025 он мян.төг	2024 он мян.төг
Харилцах дансны хүүгийн орлого	123	723
Хадгаламжийн дансны хүүгийн орлого	92,448	112,587
	92,571	**113,309**

5. Үйл ажиллагааны бус орлого

	2025 он мян.төг	2024 он мян.төг
Үйлчилгээний шимтгэл хураамжийн орлого	7,248	25,215
Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн орлого	1,770	-
	9,018	**25,215**

6. Боловсон хүчний зардал

	2025 он мян.төг	2024 он мян.төг
Үндсэн болон нэмэгдэл цалин	(31,309)	(30,753)
Ажилтнуудад олгосон тэтгэмж, нийгмийн халамж	-	(1,879)
Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын зардал	-	(1,032)
Албан томилолт		
Сургалтын зардал	-	(117)
	(31,309)	**(33,780)**

7.Арилжааны болон ханшийн тэгшитгэлийн зардал

	2025 он мян.төг	2024 он мян.төг
Ханшийн үнэлгээний өөрчлөлтийн гарз	(6,343)	-
	(6,343)	**-**

8. Үйл ажиллагааны бусад зардал

	2025 он мян.төг	2024 он мян.төг
Зээл болон түүнтэй холбоотой авлагыг барагдуулахтай холбогдон гарсан зардал	(815)	(2,487)
Аудитын төлбөр, мэргэжлийн үйлчилгээ	(9,900)	(4,880)
Зохицуулалтын үйлчилгээний хураамж	-	-
Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал	-	-

Харилцаа холбоо, интернет	(106)	(411)
Шатахуун болон тээврийн зардал	-	-
Автоматжуулалттай холбоотой урсгал зардал	(7,318)	(664)
Зар сурталчилгаа, маркетингийн судалгаа	(100)	(100)
Бичиг хэргийн зардал	(114)	-
Бусад	(3,419)	(903)
	(21,772)	**(9,444)**

9. Үйл ажиллагааны бус бусад орлого

	2025 он мян.төг	2024 он мян.төг
Үйл ажиллагааны бус орлого		
Бусад орлого	-	-
	-	-
Үйл ажиллагааны бус зардал		
Зочин төлөөлөгчийн зардал	(3,022)	(2,597)
Баяр ёслол		
Үндсэн бус үйл ажиллагааны бусад зардал		
	(3,022)	**(2,597)**
Үйл ажиллагааны бус цэвэр орлого (зардал)	**(3,022)**	**(2,597)**

10. Орлогын албан татвар

Компани нь Монгол Улсын Татварын хуулийн дагуу татварын зорилгоор татвар ногдуулахгүй орлого болон татвар ногдуулах орлогоос хасагдахгүй зардлуудын нөлөөг тооцсоны үндсэн дээр орлогын татвараа мэдүүлдэг ба 6 тэрбум төгрөг хүртэлх татвар ногдох орлогод 10 хувь, 6 тэрбум төгрөгөөс давсан татвар ногдох орлогод 25 хувийн ААН-ийн Орлогын татвар төлөх үүрэгтэй.

11. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

	2025 оны 12 сарын 31 мян.төгрөг	2024 оны 12 сарын 31 мян.төгрөг
Касс дахь бэлэн мөнгө /гадаад валют/	-	-
Банк дахь харилцах /төгрөг//80027/+	80,027	45,475
Банк дахь харилцах /гадаад валют/89/+	89	86
Банк дахь хадгаламж /төгрөг//1228400/+	1,228,400	1,260,569
Нийт мөнгөн хөрөнгө	**1,308,516**	**1,306,130**

12. Бусад актив –цэвэр

	2025 оны 12 сарын 31 мян.төгрөг	2024 оны 12 сарын 31 мян.төгрөг
Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	-	-
Бусад авлага, урьдчилгаа	97,499	2,536
	97,499	**2,536**

13.Өмч, барилга, тоног төхөөрөмж (цэвэр)

	2025 оны 12 сарын 31 мян.төг	2024 оны 12 сарын 31 мян.төг
ӨРТӨГ		
Техник хэрэгсэл	1,783	1,783
Тавилга эд хогшил	1,472	1,472
	3,255	**3,255**
ХУРИМТЛАГДСАН ЭЛЭГДЭЛ		
Техник хэрэгслийн хуримтлагдсан элэгдэл	(1,783)	(1,783)
Тавилга эд хогшлийн хуримтлагдсан элэгдэл	(1,394)	(1,310)
	(3,177)	**(3,093)**
ДАНСНЫ ЦЭВЭР ҮНЭ	**78**	**162**

14. Хувьцаат капитал

2025 оны 12 сарын 31-ний байдлаар ББСБ-ын дүрмийн сан нь 1,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 1,041,500 ширхэг энгийн хувьцаанаас бүрдэж байсан Си Жи Эф ХХК нь 100 хувь эзэмшдэг.

Энгийн хувьцаа	**2025 он**		**2024 он**	
	Дүн мян.төг	**Хувьцааны тоо**	**Дүн мян.төг**	**Хувьцааны тоо**
Зөвшөөрөгдсөн хувьцаа:				
1 сарын 1-нээр	**1,041,500**	**1,041,500**	**1,041,500**	**1,041,500**
Шинээр гаргасан хувьцаа	-	-	-	-
12 сарын 31-нээр	**1,041,500**	**1,041,500**	**1,041,500**	**1,041,500**

15. Бусад өглөг

	2025 оны 12 сарын 31 мян.төгрөг	2024 оны 12 сарын 31 мян.төгрөг
Дотоодын санхүүжилт	78,335	36,571
Гадаадын санхүүжилттэй	115,742	95,531
Бусад	0	3,700
	194,078	**135,802**

16. Өөрийн хөрөнгийн хүрэлцээ

Санхүүгийн Зохицуулах Хороо нь ББСБ-ыг эрсдэлээр жигнэсэн хөрөнгө болон өөрийн хөрөнгөд суурилан тооцсон өөрийн хөрөнгийн хүрэлцээгээ 20 хувиас багагүй байлгахыг шаарддаг. 2025 оны 12-р сарын 31-ний өдрөөр тус ББСБ-ын эрсдэлээр жигнэсэн өөрийн хөрөнгийн хүрэлцээ нь 89.62 хувь (2024 онд: 100 хувь)-тай тэнцүү байсан ба түүнийг дараах байдлаар тооцдог.

	2025 он мян.төг	2024 он мян.төг
I-р зэрэглэлийн өөрийн хөрөнгө		
Хувьцаат капитал /дүрмийн сан/	1,041,500	1,041,500
Хуримтлагдсан ашиг	170,515	131,527
I-р зэрэглэлийн өөрийн хөрөнгийн дүн	**1,212,015**	**1,173,027**
II-р зэрэглэлийн өөрийн хөрөнгийн дүн		
Нийт I ба II-р зэрэглэлийн өөрийн хөрөнгө	**1,173,027**	**1,094,751**
Эрсдэлээр жигнэсэн хүчин зүйл (%)		
0	-	318
10	-	-
20	1,306,130	1,092,977
50	-	-
100	2,698	1,456
Нийт актив	**1,308,828**	**1,094,751**
Нийт цэвэршүүлсэн актив	**264,022**	**199,331**
Сүүлийн гурван жилийн эерэг ашгийн дундаж	*12*	*16,474*
Гадаад валютын эрсдэлийн үзүүлэлт	*86*	
I зэрэглэлийн өөрийн хөрөнгө ба нийт цэвэршүүлсэн активын харьцаа	**444.29%**	**460.88%**

Нийт өөрийн хөрөнгө ба нийт цэвэршүүлсэн активын харьцаа	**89.62%**	**100.00%**

17. Эрсдэлийн удирдлага

Банк бус санхүүгийн үйл ажиллагаа нь эрсдэлийг дагуулдаг бөгөөд эрсдэлийн хязгаар тогтоох, эрсдэлийн нөлөөлөлд дүн шинжилгээ хийх, хяналт тавих замаар эрсдэлийг удирдана. Энэхүү хэсэг нь ББСБ-д учирч болох эрсдэлийн талаар дэлгэрэнгүй авч үзэн, эрсдэлийг хянахад удирдлагын ашиглах аргыг тодорхойлно.

ББСБ-д учирч болох санхүүгийн эрсдэлийн хамгийн гол хэлбэр нь зээлийн эрсдэл, төлбөр гүйцэтгэх чадварын эрсдэл, хүүгийн түвшний эрсдэлүүд байдаг бөгөөд харьцангуй бага хэмжээнд учирч болох эрсдэл нь гадаад валютын эрсдэл болно.

Эдгээр эрсдэлүүд болон тэдгээрийг удирдах арга замын талаар дор авч үзэв:

(i) Зээлийн эрсдэл

ББСБ-ын зээлийн үндсэн эрсдэл нь зээл болон урьдчилгаагаар дамжин үүсдэг. Энэ тохиолдолд зээлийн эрсдэлтэй дүн нь баланс дахь хөрөнгийн дансны үнээр илэрхийлэгдэнэ.

Тус ББСБ нь нэг зээлдэгч буюу нэг бүлэг зээлдэгч болон нэг салбарт олгож болох зөвшөөрөгдсөн эрсдэлийн дүнгийн хязгаарыг тогтоох замаар зээлийн эрсдэлийн түвшингээ тодорхойлдог. Зээлийн эрсдэлд орж болох байдлаа ББСБ нь зээлдэгчид болон томоохон зээлдэгчийн хүүгийн төлбөр, зээлийн эргэн төлөлтийн хариуцлагаа биелүүлж чадах чадварын шинжилгээгээр удирддаг. Шаардлагатай үед зээлийн хязгаарыг өөрчилдөг. Зээлийн эрсдэлийг мөн барьцаа хөрөнгө болон байгууллага, хувь хүний гаргасан баталгаагаар удирддаг.

ББСБ-ын харилцагчдад зээл, урьдчилгаа олгосон салбараас шалтгаалан зээлийн төвлөрлийн эрсдэл бий болдог.

	2025 он мян.төг	**2024 он мян.төг**
Том зээлдэгчид олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив (40 том зээлдэгчээр)	-	-
Том зээлдэгчид олгосон зээл, зээлтэй адилтгах тооцох бусад актив (Хамгийн том зээлдэгч)	-	-
Хувь нийлүүлэгч, өөрийн ажилтан, холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив	-	-
Хувь нийлүүлэгч, өөрийн ажилтан, холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив (Хамгийн том зээлдэгч)	-	-
Өөрийн хөрөнгө	**1,212,015**	**1,173,027**

Том зээлдэгчид олгосон зээл, зээлтэй адилтгах тооцох бусад активын өөрийн хөрөнгөд эзлэх хувь	-	-
Хувь нийлүүлэгч, өөрийн ажилтан, холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтгах тооцох бусад активын өөрийн хөрөнгөд эзлэх хувь	-	-

(ii) Гадаад валютын эрсдэл

Тус ББСБ нь гадаад валютаар ажил гүйлгээ хийдэггүй учир гадаад валютын эрсдэлд өртөх магадлалгүй.

18. Зах зээлийн бодит үнийн мэдээлэл

ББСБ-ын санхүүгийн хэрэгслүүдийн томоохон хэсэгт зориулсан идэвхтэй зах зээл байхгүй учраас өнөөгийн эдийн засгийн нөхцөл байдал болон тухайн хэрэгсэлд хамаарах эрсдэлд тулгуурлан зах зээлийн бодит үнийг тогтоох шийдвэр гаргадаг. Эдгээр тооцооллууд дээр үндэслэн санхүүгийн актив болон пассивын зах зээлийн үнийг дансны үнээс мэдэгдэхүйц зөрүүгүй гэж үзсэн. Санхүүгийн хэрэгслүүдийн зах зээлийн бодит үнэ цэнийг тогтооход дараах арга, таамаглалуудыг ашигладаг. Үүнд:

(i) Зээл ба урьдчилгаа

Зээлийн багцын зах зээлийн бодит үнэ цэнэ нь зээл бүрийн хүүгийн түвшин болон зээлдэгчийн санхүүгийн чадавхид суурилагддаг. Зээл эргэн төлөгдөхөд учирч болзошгүй алдагдлаас хамгаалах санг тооцохдоо зээлдэгчийн өнөөгийн байдал болон авсан барьцаа зэрэг хүчин зүйлсэд үндэслэн зээлийн төрөл бүрт хэрэглэгдэх эрсдэлийн урамшууллыг авч үздэг. Зээлийн эрсдэлээс хамгаалах санд зээлийн эрсдэлийн нөлөөг тусгахад шаардагдах хөнгөлөлтийн тооцооллыг ул үндэстэй судалдаг. Зээлийн дансны үнийг зээлийн зах зээлийн ул үндэстэй үнэ цэнэ гэж үзэх үндэслэлтэй.

(ii) Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны үнэ нь анхны үнээс хуримтлагдсан элэгдэл болон үнийн бууралтыг хассан цэвэр үнэ цэнээр тусгагддаг. Үндсэн хөрөнгийн дансны үнийг зээлийн зах зээлийн ул үндэстэй тооцоологдсон үнэ гэж үзэх үндэслэлтэй.

19. Харьцуулах үзүүлэлтүүд

Тодорхой харьцуулах үзүүлэлтүүдийг тайлант жилийн тайлагналтай нийцүүлэх үүднээс дахин ангилсан болно.

20. Балансын дараах үйл явдал

Санхүүгийн тайланд тодруулахуйц балансын дараах үйл явдал гараагүй болно.